

ОНХС-ийн хөрөнгийг олон хүнд хэрэгтэй зүйл хийлгэхэд зарцуулах учиртай юм байна шүү дээ.

Тийм ээ, өнгөрсөн жилүүдэд манай суманд ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн ажлууд:


Авто зам, гэрэлтүүлэг



Халуун ус, худаг



Спорт заал, дотуур байрны их засвар



Бэлчээр хамгаалах хашаа, худаг ус, мал угаалгын газар



www.tusuv-oronnutag.mof.gov.mn

БҮРД ЗДТГ



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

2022 онд хийгдсэн ажлууд

Сумын төвийн Чигчий хорооллын гэрэлтүүлэг хийснээр иргэд ая тухтай таатай эрсдэлгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдлээ.
Төсөвт өртөг: 10.0 сая төгрөг Гүйцэтгэгч: “Үнэмч” бүлэг



Орон нутгийн музей засварын ажил хийгдсэнээр барилгын өнгө үзэмж сайжирч иргэдэд ая тухтай үйлчилгээ үзүүлэх боломж бүрдлээ.
Төсөвт өртөг: 7.6 сая төгрөг Гүйцэтгэгч: Иргэн Б. Энхсугар



СӨББайгууллагын гаднах тоглоомын талбайн тохижилт хийснээр цэцэрлэгийн насны хүүхдүүд цэвэр агаарт чөлөөт цагаа зөв өнгөрөөх нөхцөл бүрдлээ.
Төсөвт өртөг: 20.0 сая төгрөг Гүйцэтгэгч: “Өсөх-Ирээдүй” бүлэг



ЕБСургуулийн гаднах биеийн тамирын талбай шинээр баригдсанаар хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, сурагчдын бие бялдыг хөгжүүлэх болон чөлөөт цагаа зөв өнгөрөөх нөхцөл бүрдлээ.
Төсөвт өртөг: 12.0 сая төгрөг Гүйцэтгэгч: “Үнэмч” бүлэг



Хүүхдийн тоглоомын талбай барих ажил хийгдсэнээр хүүхдүүд чөлөөт цагаа найзуудтайгаа зөв боловсон өнгөрөөж аюулгүй байдлын хүрээнд 4 ш гэрэл, 2 ш камер суурилуулсан.
Төсөвт өртөг: 20.0 сая төгрөг Гүйцэтгэгч: “Өсөх-Ирээдүй” бүлэг



Соёлын төвийн хайс шинээр барих ажил хийгдсэнээр орчны тохижилт болон газар ашиглалт сайжирсан.
Төсөвт өртөг: 10.0 сая төгрөг Гүйцэтгэгч: “Өсөх-Ирээдүй” бүлэг



Сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт хийж усан оргилуур болон гэрэлтүүлэг ашиглалтад орлоо.
Төсөвт өртөг: 9.0 сая төгрөг Гүйцэтгэгч: “Өсөх-Ирээдүй” бүлэг



Хортон мэрэгч устгах ажил хийснээр бэлчээрийн хортон мэрэгч тархсан талбайн хэмжээ буурч сумын хэмжээнд бэлчээр, хадлангийн ургац нэмэгдэж, малын тэжээлийн нөөц бүрдэх нөхцөл бүрдлээ.

Төсөвт өртөг: 26.9 сая төгрөг Гүйцэтгэгч: “Шим” ХХК





ОНХС-ИИН
ҮЙЛ АЖИЛЛАГАА
ИРГЭН ТАНД
ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ
БАЙНА



Малын тэжээлийн ургамал тариалах тоног төхөөрөмж худалдан авснаар малчид өөрсдийн хөдөлмөрөөр хямд өртгөөр тэжээлээ тарьж бэлтгэн тэжээлийн нөөц бүрдэх таатай нөхцөл бүрдлээ.
Төсөвт өртөг: 139.5 сая төгрөг
Гүйцэтгэгч: “Техникхаус” ХХК

